



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 4/128

Дадал сум

Зардал гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 5.5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хоггүй Дадал” арга хэмжээний хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх, цэвэрлэгээ үйлчилгээний бичил тоног төхөөрөмж худалдан авах зардал гаргасугай.

2.Зардлын 20,000,000 (Хорин сая) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Энхзул)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (Д.Агаармандал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000377